



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Бага тойруу, Хуульчдын талбай, Утас/Факс: (976-51) 26 26 37,
И-мэйл: turiintusgaiemneleg@gmail.com,
Вэбсайт: www.ghsss.gov.mn

2020.01.30 № 114
танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус эмнэлгээс цахим хэлбэрээр зарласан Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТТАХНЭ/202012012 дугаар бүхий тендерийн баримт бичгийн Техникийн тодорхойлолтын зарим багцын эмнэлгийн хэрэгсэлд тавигдаж буй шаардлагаас тендерт оролцогч байгууллага тодруулга хүссэн тул тендерийн баримт бичигт дараах тодруулгыг оруулж байна. Үүнд:

Нэг. Багц 2 буюу Бөөрний мэс заслын хэрэгсэл

1. Тендерийн баримт бичигт буй Багц 2 буюу Бөөрний мэс заслын хэрэгслийн 1 дүгээр бараа, бүтээгдэхүүн болох Уян дурангийн чиглүүлэгч хоолой (S0253) нь 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 17 дугаар тогтоолоос хасагдаагүй байна. Уг тогтоолын 10.3 дугаараас харж болно.
2. Мөн 6 дугаар бараа, бүтээгдэхүүн болох Шээлгүүрийн катетрийн хэмжээ 18ch мөн бөгөөд Тендерийн баримт бичгийн 61 дүгээр хуудаснаас харж болно.

Хоёр. Багц 4 буюу Эрүү нүүрний мэс заслын хэрэгсэл

1. Титан рамк нэг талын эрүү (хэлбэржүүлэгч, ялтас, шураг, бэхлэгч, холбогч, таслагч) Reconstruction plate – техникийн тодорхойлолтонд ялтасны нүхний тоо орхигдсон тул ялтасны нүхний тоог 10 нүхтэй гэж нэмж оруулж байна.
2. Титан ялтас Mandible straight fracture plate – ялтасны нүхний тоог Тендерийн баримт бичгийн 61 дүгээр хуудаснаас харж болно.

Гурав. Багц 7 буюу Гавлын ясны дутмагшил

1. Цус тогтоогчийн техникийн тодорхойлолтыг Hemostatic sponge буюу нэг удаагийн хэрэглээний шимэгддэг цус тогтоох целлюлоз 5см х 35см хэмжээтэй гэж өөрчилж байна.
2. Ликворын гуурсын техникийн тодорхойлолтод ховдлын гуурс буюу тархины цусан хурааг гадагшлуулах зориулалтын синтетик материалтай урсгуур бөгөөд уг бүтээгдэхүүн нь S0040 биш 17 дугаар тогтоолд заагдсаны дагуу S0049 болно.

Тус эмнэлгээс зарласан Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ТТАХНЭ/202012012 дугаар бүхий тендерийн баримт бичгийн Өндөр өртөг эмнэлгийн хэрэгслүүдийн дэлгэрэнгүй жагсаалт, техникийн тодорхойлолтын холбогдох хэсэгт оруулсан дээрх тодруулгын дагуу тендерийн баримт бичгээ бэлтгэж ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ,
ДЭД ХУРАНДАА



Л.БАТТӨР